



Japan
Fund for
Poverty
Reduction



L3605/G9191 : MON48076 - ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН ОРОЛЦООГ ХАНГАХ, ҮЙЛЧИЛГЭЭГ САЙЖРУУЛАХ ТӨСӨЛ

АЖЛЫН ДААЛГАВАР

С9 - БАЙГАЛЬ ОРЧНЫ МЭРГЭЖИЛТЭН

А. ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам, Азийн хөгжлийн банкттай хамтран “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоог хангах үйлчилгээг сайжруулах төсөл”-ийг 2018-2022 онд хэрэгжүүлж байна. Тус төсөл нь Улаанбаатар хот болон аймгуудын хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлэх үйлчилгээг сайжруулах, бие даан амьдрах чадварыг дээшлүүлж, нийгэм эдийн засагт тэдний оруулах хувь нэмрийг нэмэгдүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилготой юм. Төсөл нь дараах бүрэлдэхүүн хэсгүүдтэй. Үүнд: Бүрэлдэхүүн 1: Хөгжлийн бэрхшээлийг эрт илрүүлэх чадавхыг бэхжүүлж, тогтолцоог бүрдүүлэх, Бүрэлдэхүүн 2: ХБИ- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд чиглэсэн үйлчилгээний хүртээмжийг сайжруулах. Бүрэлдэхүүн 3: Орчны хүртээмжийг сайжруулах, Бүрэлдэхүүн 4: ХБИ-ийн ажил, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, Бүрэлдэхүүн 5: ХБИ-ийг дэмжих стратегийг хэрэгжүүлэх.

Б. ЗӨВЛӨХ АЖЛЫН ЗОРИЛТУУД

- Мэргэжилтэн нь төслийн хүрээнд хийгдэж буй бүх барилгын ажлын байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хянаж, зохицуулахад ХНХЯ болон ТХН-д дэмжлэг үзүүлэн ажиллана.
- Мэргэжилтэн нь Улаанбаатар хотод барих Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төвийн байгаль орчны ерөнхий үнэлгээний төслийг эцэслэн боловсруулахад ТХН болон ХНХЯ-нд дэмжлэг үзүүлэн ажиллана.

Ажлын байрны зорилтын хүрээнд хийж гүйцэтгэх ажил, үйлчилгээ 1:

- ХБИ-ийн Хөгжлийн төвүүдийг барих ажилд ямар нэг байдлаар албадан нүүлгэн шилжүүлэлт хийхгүй байхад анхаарах;
- Байгаль орчны удирдлагын ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсан байгаль орчинтой холбоотой нарийвчилсан зааварчилгааг барилгын ажлуудын тендерийн баримт бичигт тусгахад дэмжлэг үзүүлж, хамтран ажиллах
- Барилгын ажлуудын тендерийн үнэлгээг хийхэд Байгаль орчны удирдлагын ерөнхий төлөвлөгөөний зааварчилгааг баримталсан эсэхэд хяналт тавьж, хамтран ажиллах;
- Тендерт шалгарсан гэрээт байгууллагууд болон ТХН-д төслийн байгаль орчны удирдлагын шаардлага болон зохицуулалтын талаар

зөвлөгөө өгөх, өргөдөл гомдол барагдуулах механизмыг бэхжүүлэхэд туслах;

- Барилгын ажлыг гүйцэтгэх гэрээт компаниудын боловсруулсан барилгын талбайн байгаль орчны удирдлагын төлөвлөгөөний хэрэгжилтийг төсөл хэрэгжүүлэгчдийн зөвшөөрлөөр хянаж, зөвлөгөө өгөх;
- Барилгын ажлын талбай бүрд доод тал нь 2 удаа (барилгын ажил эхлэх болон дуусах үеэр) очиж нөхцөл байдалтай танилцах, зөвлөгөө өгөх;
- Байгаль орчны удирдлагын төлөвлөгөөний хэрэгжилтийн талаарх явцын тайланг хяналт тавьсан тухай бүр жил бүр бэлтгэж танилцуулах (барилгын ажил гүйцэтгэх гэрээт компаниудыг үүрэг хариуцлагаа биелүүлж буй эсэх, үйл ажиллагаанд тавьсан хяналтын үр дүнгүүд, сэргээн босголт болон үйл ажиллагааны явцад гарсан асуудлууд, тэдгээрийг засаж, сайжруулах чиглэлээр авсан арга хэмжээнүүдийг тайланд тусгах);
- Архитектор, инженерийн хамт барилгын ажил дуусгах хяналт тавьж, Засгийн Газрын холбогдох байгууллагуудтай хамтран барилга бүрийн хэвийн, аюулгүй байдлыг баталгаажуулан анхаарч ажиллах;
- Төслийн хүрээнд баригдах бүх барилгын ажлыг дуусгаснаас хойш 3 сарын дотор байгаль орчны удирдлагын төлөвлөгөөний хэрэгжилтийн эцсийн тайланг бэлдэх (Англи, Монгол хэлээр).

Ажлын байрны зорилтын хүрээнд хийж гүйцэтгэх ажил, үйлчилгээ 2:

- Улаанбаатар хотод барих Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төвийн барилгын ажлын 2017 онд хийгдсэн байгаль орчны ерөнхий үнэлгээг хийх; сайжруулах, шинэчлэн боловсруулах
- Байгаль орчин, аялал жуулчлалын яам, бусад холбогдох байгууллагаас Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төвд шаардлагатай байгаль орчны ерөнхий үнэлгээний зөвшөөрлийг авах.